



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар A/164

Өмнөдэлгэр сум

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг 2024-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Архины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх архидалтгүй сум арга хэмжээний хүрээнд архины хамааралтай өрх толгойлсон олон хүүхэдтэй 2 эхийг сайн дурын эмчилгээнд хамруулсугай.

2.Эмчилгээнд хамрагдахад шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР

## **ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН “АРХИГҮЙ ХЭНТИЙЧҮҮД” ДЭД ХӨТӨЛБӨР**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1 Хөтөлбөр боловсруулах үндэслэл**

Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ нь иргэдийн эрүүл мэнд, гэр бүлийн тогтвортой байдал, хөдөлмөрийн бүтээмж, нийгмийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, гэмт хэрэг, зөрчил, осол гэмтэл, ядуурал, хүүхдийн хүчирхийлэл зэрэг олон асуудлын үндэс болж байна. Иймд архины зохисгүй хэрэглээг бууруулах, иргэдийн зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулав.

#### **1.2 Хууль эрх зүйн үндэслэл**

Энэхүү дэд хөтөлбөр нь дараах хууль тогтоомж, бодлогын баримт бичигт үндэслэнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Засгийн газрын болон аймгийн Засаг даргын холбогдох бодлого, шийдвэр
- “Архигүй Хэнтийчүүд” аймгийн дэд хөтөлбөр

#### **1.3 Хөтөлбөрийн хамрах хүрээ**

Энэхүү дэд хөтөлбөр нь Өмнөдэлгэр сумын төрийн байгууллага, аж ахуйн нэгж, боловсрол, эрүүл мэндийн байгууллага, иргэд, гэр бүл, хүүхэд залуучууд болон олон нийтийг хамарна.

### **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

#### **2.1 Нийтлэг зорилго**

Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээг бууруулах, архинаас үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг багасгах, иргэдийн эрүүл зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, архигүй орчин бүрдүүлэхэд оршино.

#### **2.2 Рорилтууд**

##### **Зорилт 1.**

Архи, согтууруулах ундааны хор нөлөөний талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлнэ.

##### **Зорилт 2.**

Архи, согтууруулах ундааны худалдаа, хэрэглээнд тавих хяналт, хариуцлагыг сайжруулна.

Зорилт 3.

Хүүхэд, залуучуудыг архины хэрэглээнээс урьдчилан сэргийлэх ажил, нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлнэ.

Зорилт 4.

Архины хамааралтай иргэдийг эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн сэргээн засах үйлчилгээнд хамруулах ажлыг дэмжинэ.

Зорилт 5.

Архины хамааралтай иргэдийн албадан эмчилгээнд хамруулна.

### **ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1. Архи, согтууруулах ундааны хор нөлөөний талаарх сургалт, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах
2. Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдах, үйлчлэх зөрчилд хяналт шалгалт хийх
3. Архины хамааралтай иргэдийг зөвлөгөө, эмчилгээ, албадан эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд хамруулах
4. Олон нийтийн спорт, урлаг, соёлын арга хэмжээг нэмэгдүүлэх
5. Сошиал болон мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг, сурталчилгаа хүргэх
6. Хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулах

### **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЕ ШАТ**

#### **4.1 Нэгдүгээр үе шат (2025-2026)**

- Судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ хийх
- Иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх
- Хяналт шалгалтыг эрчимжүүлэх
- Архигүй орчны суурийг бүрдүүлэх

#### **4.2 Хоёрдугаар үе шат (2027-2028)**

- Архины хэрэглээг бууруулах тогтвортой үр дүнд хүрэх
- Архигүй соёлыг төлөвшүүлэх
- Иргэдийн оролцоонд суурилсан тогтолцоог бэхжүүлэх

### **ТАВ. САНХҮҮЖИЛТ**

Хөтөлбөрийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- Орон нутгийн төсөв

- Аймаг, улсын төсөвт тусгагдсан хөрөнгө
- Төсөл хөтөлбөр
- Аж ахуйн нэгж, байгууллагын дэмжлэг
- Иргэд, олон нийтийн оролцоо

### **ЗУРГАА. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах үзүүлэлтээр үр дүнг тооцно:

- Архидан согтууралттай холбоотой зөрчил, гэмт хэргийн бууралт
- Архины хэрэглээний талаарх иргэдийн мэдлэгийн түвшин
- Архигүй орчин бүрдүүлсэн байгууллага, өрхийн тоо
- Сургалт, нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн тоо
- Архины хамааралтай иргэдийн эмчилгээ, зөвлөгөөнд хамрагдсан байдал

Хяналт-шинжилгээ, үнэлгээг сумын Засаг даргын Тамгын газар холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

### **ДОЛОО. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**

Хөтөлбөр хэрэгжсэнээр:

- Архины зохисгүй хэрэглээ буурна.
- Иргэдийн эрүүл мэнд, амьдралын чанар сайжирна.
- Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил буурна.
- Хүүхэд, залуучуудын зөв дадал хэвшил төлөвшинө.
- Архины хамааралтай иргэдийн тоо буурна.
- Олон нийтийн оролцоо, хариуцлага сайжирна.

### **НАЙМ. ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

Хөтөлбөрийн хэрэгжилтийг Өмнөдэлгэр сумын Засаг даргын Тамгын газар нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.